



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А / 111

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Монгол улсын Шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгчийн нэрэмжит биеийн тамирын 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Орлогч дарга Б.Бат-Эрдэнэ, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид нарт тус тус даалгасугай.
3. Тус журмыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ БИЕЙН ТАМИРЫН 4 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрдэм шинжилгээний байгууллагын ажиллагсадын дунд биеийн тамирын 4 төрөлт тэмцээн (цаашид “тэмцээн” гэх) зохион байгуулах, нийлбэр үзүүлэлтээр тэргүүлсэн цомын эзэн байгууллагыг шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Тэмцээний зорилго нь Шинжлэх ухааны салбарт ажиллагсадын дунд нийтийн биеийн тамирыг дэлгэрүүлэх, хөгжүүлэх, эрүүл мэндийг нь сайжруулахад оршино.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулж явуулах

- 2.1. Тэмцээнийг Монгол улсын Шинжлэх ухааны Академи (цаашид “ШУА” гэх), Шинжлэх ухааны байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороо (цаашид “нэгдсэн хороо” гэх) Эрдэм шинжилгээний байгууллагууд хамтран зохион байгуулна.
- 2.2. Тэмцээнийг жилд нэг удаа, дор дурдсан төрөл тус бүрээр зохион байгуулна:
 - 2.2.1. Сагсан бөмбөг, эрэгтэй баг;
 - 2.2.2. Сагсан бөмбөг, эмэгтэй баг
 - 2.2.3. Волейбол, эрэгтэй баг;
 - 2.2.4. Волейбол, эмэгтэй баг;
 - 2.2.5. Шатар, эрэгтэй;
 - 2.2.6. Шатар, эмэгтэй;
 - 2.2.7. Ширээний теннис, эрэгтэй;
 - 2.2.8. Ширээний теннис, эмэгтэй;
- 2.3. Тэмцээнийг Шинжлэх ухааны ажилтны өдрийн арга хэмжээний хүрээнд жил бүрийн 10, 11 дүгээр сард зохион байгуулна.
- 2.4. Тэмцээний зардлыг зохион байгуулагч болон оролцогч талууд хамтран бүрдүүлж болно.
- 2.5. Тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулна.
- 2.6. Тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн эрх, үүрэг.
 - 2.6.1. Тэмцээний нэгдсэн хуваарийг гаргаж, ажлын хэсгийн хурлаар батлуулах;
 - 2.6.2. Ерөнхий шүүгчийг томилох;
 - 2.6.3. Багуудын техникийн зөвлөгөөнийг товлон хуралдуулах;
 - 2.6.4. Тэмцээний хуваарийг мэдээлэх;
 - 2.6.5. Тэмцээнийг стандартын шаардлага хангахуйц байранд явуулах;
- 2.7. Тэмцээний ерөнхий шүүгчийн эрх, үүрэг.
 - 2.7.1. Тэмцээний хуваарийг үндэслэн техникийн зөвлөгөөнийг удирдах;
 - 2.7.2. Тоглолтын нарийвчилсан хуваарь, оноолтыг гаргах;
 - 2.7.3. Тоглолтын шүүгчдийг томилох;
 - 2.7.4. Тэмцээний үеэр гарсан аливаа маргааныг хянаж, эцэслэн шийдвэрлэх;
 - 2.7.5. Журмын дагуу нийлбэр оноог гаргаж ажлын хэсэгт танилцуулах.

Гурав. Тэмцээнд оролцох багт тавих шаардлага

- 3.1. Тэмцээнд оролцох баг нь Шинжлэх ухаан технологийн тухай хуульд заагдсан эрдэм шинжилгээний байгууллага байна.

- 3.2. Тэмцээнд оролцогч нь тухайн эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй сар НДШ төлж ажиллаж байгаа үндсэн ажилтан, албан хаагч байна.
- 3.3. Тэмцээнд оролцох эрх нь иргэний үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтэрээр баталгаажина.
- 3.4. Тэмцээнд тухайн эрдэм шинжилгээний байгууллагад урт хугацаа (6 сар, түүнээс дээш)-гаар ажиллаж байгаа гадаадын ажилтнууд оролцож болно.
- 3.5. Эрдэм шинжилгээний байгууллага нь тэмцээнд оролцох баг тамирчдаа тоглолтын хувцсаар жигдэрүүлсэн байна.
- 3.6. Тэмцээнд оролцох багууд спортын төрөл бүрээр дараах тооны тамирчдыг мэдүүлэгтээ бичсэн байна.
 - 3.6.1. Сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 8 хүнтэй,
 - 3.6.2. Волейболын тэмцээнд эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 9 хүнтэй,
 - 3.6.3. Шатрын тэмцээнд эрэгтэй 3, эмэгтэй 2 хүнтэй,
 - 3.6.4. Ширээний теннисний тэмцээнд эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 хүнтэй.
- 3.7. Тухайн байгууллагаас төрөл тус бүр дээр зөвхөн 1 баг оруулцуулах эрхтэй.

Дөрөв. Цомын эзэн байгууллагыг тодорхойлох

- 4.1. Эрдэм шинжилгээний байгууллагаас тэмцээний бүх төрөлд баг тамирчдаа оролцуулж багийн нийлбэр дүнгээр хамгийн бага оноо авсан багийг Аварга багаар тодруулна.
- 4.2. Спортын төрөл бүрээр байр эзэлсэн багууд Аварга баг шалгаруулах дүнд тооцогдох оноог дараах байдлаар авна. Үүнд:
 - 1-р байр 1 оноо,
 - 2-р байр 2 оноо,
 - 3-р байр 3 оноо,
 - 4-р байр 4 оноо гэх мэт
- 4.2.1. Багуудын нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд эмэгтэй волейболын тэмцээнд түрүүлсэн багийн дүнгээр шалгаруулна.

---oooOooo---